МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

# “ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА” ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН, ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Г.ТЭМҮҮЛЭН

2023 ОН
УЛААНБААТАР

# ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

| | Хууль, тогтоомж | Өөрчлөлт |
|---|---|---|
| 1 | Төсвийн тухай хууль | Нэмэлт, өөрчлөлт |
| 2 | Төсвийн тогтвортой байдлын тухай хууль | Нэмэлт |
| 3 | Төрийн аудитын тухай хууль | Нэмэлт, өөрчлөлт |
| 4 | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль | Нэмэлт, өөрчлөлт |
| 5 | Өрийн удирдлагын тухай хууль | Нэмэлт өөрчлөлт |
| 6 | Ирээдүй өв сангийн тухай хууль | Нэмэлт, өөрчлөлт |
| 7 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль | Нэмэлт |
| 8 | Монгол Улсын Их Хурлын тухай | Өөрчлөлт |
| 9 | Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль | Нэмэлт, өөрчлөлт |
| 10 | Хууль тогтоомжийн тухай хууль | Нэмэлт, өөрчлөлт |
| 11 | Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль | Нэмэлт |
| 12 | Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль | Нэмэлт |
| 13 | Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх тухай хууль | Шинэ |
| 14 | УИХ-ын Тогтоолд өөрчлөлт оруулах тогтоол | Шинэ |

# ТӨСВИЙН ЦАГЛАБАР – Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төрийн аудитын тухай хууль

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ
2023-07-07



ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ
2023-07-07

# Аудитын үйл ажиллагаа




## 8 дугаар зүйл.Санхүүгийн тайлангийн аудит

8.8. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын тайланд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитын үр дүнг төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрэх үр дүнгийн үзүүлэлттэй харьцуулан тусгана.

## 11 дүгээр зүйл.Аудитын төлөвлөлт

11.1.Монгол Улсын Ерөнхий аудитор аудитын сэдвийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

11.2.Энэ хуулийн 11.1-д заасан аудитын сэдвийг дараах байдлаар ангилна:

11.3.4.төрийн аудитын байгууллагын аудитын сэдэвт санал авах хугацаанд иргэд, олон нийтээс ирүүлсэн санал.

## 20 дугаар зүйл.Төрийн аудитын тайлан

20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ
2023-07-07

# 70 дугаар зүйл. Төсвийн хяналт, хариуцлага

70.2.Энэ хуулийн $28^{1}$.2, $28^{1}$.4-т заасныг удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан мөрдөж ажиллаагүй нь тогтоогдсон бол ажлаас халах үндэслэл болно.

$28^{1}$ дүгээр зүйл.Төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах

$28^{1}$.2.1. иргэд, иргэний нийгмийн байгууллага, энэ хуулийн 10.2-т заасан Зөвлөл, төрийн аудитын байгууллага болон хэлэлцүүлгийн асуудалтай холбоотой салбарын асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын удирдах албан тушаалтан, санхүү, төсвийн асуудал хариуцсан холбогдох албан тушаалтныг оролцуулсан байх;

70.3.Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн төсвийн тухай хуульд заасан зардлыг хэтрүүлсэн, ангилал зөрүүлсэн, зориулалт бусаар ашигласан бол тухайн эрхэлж байгаа албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно.

70.4.Төсвийн ерөнхийлөн захирагч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн төслийг боловсруулж, батлуулахдаа үндэслэлгүй тоо мэдээнд тулгуурлан батлуулсан нь төсвийн гүйцэтгэлээр тогтоогдсон бол уг албан тушаалтныг албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно.

ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ
2023-07-07

# 42 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

42.1.Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

42.2.Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

42.3.Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.

42.4.Энэ хуулийн 42.1, 42.2-т заасны дагуу тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөхөд бусад хуульд заасан үндэслэл, журам үйлчлэхгүй.

42.5.Төрийн аудитын байгууллагын албан хаагч төрийн аудитын нийтлэг стандарт, ёс зүйн дүрмийг зөрчсөн, хуульд заасан албан үүргээ биелүүлээгүй бол Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ
2023-07-07

# 37 дугаар зүйл.Төрийн аудитын нээлттэй, ил тод байдлыг хангах

37.2.Төрийн аудитын байгууллага төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан журмын дагуу улирал бүр гаргаж, өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

---

37.6.Энэ хуулийн 11.3.4-т заасан саналыг аудитын сэдвийг батлахад тусгасан эсэх талаарх үндэслэл, тайлбарыг Төрийн аудитын байгууллагын цахим хуудсаар иргэд, олон нийтэд ил тод мэдээлнэ.

# 28 дугаар зүйл. Олон нийтийн оролцоо

28[1].2. Жил бүрийн 8 дугаар сард Төсвийн тодотгол төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд багтаан зохион байгуулах,

28[1].4. Жил бүрийн 3 дугаар сард багтаан Төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг өргөнө мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд  зохион байгуулах,

# ОЛОН НИЙТИЙН САНАЛ, ОРОЛЦОО

Улсын **хөрөнгө оруулалтын хөтөлбөрт** тусгуулах төсөл, арга хэмжээний саналыг санал боловсруулах **бүх шатанд олон нийтэд хэлэлцүүлсэн байна**; (Төсвийн тухай хуулийн 28.2.1)

Улсын **хөрөнгө оруулалтын хөтөлбөрт** хэрэгжих орон нутгийн **иргэдийн саналыг** авсан байна;" (Төсвийн тухай хуулийн 28.2.2 заалт)

Төрийн аудитын байгууллагын **аудитын сэдэвт** санал авах хугацаанд иргэд, **олон нийтээс санал авах** (Төрийн Аудитын тухай хууль 11.3.4 заалт)

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 07 өдөр | Дугаар 09 | Улаанбаатар хот

### Аудитын сэдэв батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.8.3 дахь заалтыг тус тус үндэслэн Төсвийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын сэдвийг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолын хавсралтад заасан аудитыг хугацаанд нь гүйцэтгэж, аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, гишүүдэд хүргүүлж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудитор (Д.Занданбат)-т үүрэг болгосугай.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Г.ТЭМҮҮЛЭН

# 2023 ОНД БОДЛОГООР ГҮЙЦЭТГЭХ АУДИТ



- Монгол Улсын Засгийн газраас “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний явц, үр дүн
- Төрөөс шинжлэх ухаан, технологийн салбарын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт, үр нөлөө
- Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэл
- Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж



# 2023 ОНД БОДЛОГООР ГҮЙЦЭТГЭХ АУДИТ



- Үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн болон валютын ханшны өөрчлөлтийг тогтворжуулах бодлогын үр нөлөө
- Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөө
- Хөгжлийн банкны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашиг
- Татан буугдсан банктай холбоотой шийдвэрүүдийн хэрэгжилт, үр нөлөө



- Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө
- Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө

# 2023 ОНД БОДЛОГООР ГҮЙЦЭТГЭХ АУДИТ

2023 онд УИХ-ын Байнгын хороод Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын тайлангуудыг хэлэлцэн шийдвэрлэж, Засгийн газарт холбогдох чиглэлийг өгч ажилласан байна.

МУ-ын 2022 оны ЗГНСТ, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн үр дүнг УИХ-ын нэгдсэн чуулган, 11 байнгын хороодоор хэлэлцсэний дараа төсвийн гүйцэтгэлийг батлах болон Засгийн газарт чиглэл өгч, Төрийн аудитын байгууллагын аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр УИХ-ын 2023 оны 66, 67 дугаар тогтоол гарсан байна.



Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцооны үр дүн, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн



Эрчим хүчний дамжуулалт, түгээлтийн өнөөгийн байдал



Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт



Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө



Агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлээр зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр нөлөө

# 2023 ОНД БОДЛОГООР ГҮЙЦЭТГЭХ АУДИТ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 06 өдөр Дугаар 62 Төрийн ордон, Улаанбаатар хот

**Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 10,235,124.6 сая /арван их наяд хоёр зуун гучин таван тэрбум нэг зуун хорин дөрвөн сая зургаан зуун мянга/ төгрөгөөр батлагсугай.

2.Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 11,359,914.0 сая /арван нэгэн их наяд гурван зуун тавин есөн тэрбум есөн зуун арван дөрвөн сая/ төгрөгөөр батлагсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МУ-ын 2022 оны ЗГНСТ, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн үр дүнг УИХ-ын нэгдсэн чуулган, 11 байнгын хороодоор хэлэлцсэний дараа төсвийн гүйцэтгэлийг батлах болон Засгийн газарт чиглэл өгч, Төрийн аудитын байгууллагын аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр УИХ-ын 2023 оны 62, 67 дугаар тогтоол гарсан байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 06 өдөр Дугаар 67 Төрийн ордон, Улаанбаатар хот

**Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоол баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

1/Монгол Улсын Засгийн газраас боловсруулан өргөн мэдүүлж байгаа тухайн жилийн төсвийн төсөл, гүйцэтгэлийн дүн, батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэлтэй зөрж байгаад дүн шинжилгээ хийх, холбогдох хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хариуцлагажуулах зорилгоор хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналаа боловсруулан Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан хяналтын сонсголыг төсвийн гүйцэтгэлийн хэлэлцүүлэгтэй уялдуулан зохион байгуулах шаардлагад нийцүүлэн Монгол Улсын тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийг тайлагнах, аудит хийх, өргөн мэдүүлэх, батлах хугацаанд өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулан Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/Монгол Улсын тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулгад төсвийн орлого, зарлагыг эдийн засгийн ангиллаар болон төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн баталсан төсвөөс зөрүүтэй зарцуулсан шалтгааныг тайлбарласан дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргаж байх;

4/Зээлийн үйлчилгээний төлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэлийн зөрүү их байгаад дүгнэлт хийж, цаашид төсвийг бодитой төлөвлөж ажиллах.

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

# ДҮГНЭЛТ

- Хууль батлагдсанаар төсвийн ил тод байх, хариуцлагатай байх, төсөв тогтвортой байх зарчмын хэрэгжилтийг хангах эрх зүйн орчин бүрдлээ. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, төсвийн төслийг боловсруулахад иргэд, олон нийтээс заавал санал авч, хэлэлцүүлдэг байх, ийнхүү санал авалгүйгээр төсвийн саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцох нөхцөлийг тусгасан.

- Төсвийн төлөвлөлтөд Засгийн газрын чиг үүрэг, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх нөхцөлийг нарийвчлан тусгасан. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад үндэслэл болгон ашигладаг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг зөвхөн Засгийн газар дангаар бус Улсын Их Хурлын дэргэдэх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс мөн боловсруулдаг байхаар хуульд тусгасан бөгөөд уг тооцооллыг олон талаас, нарийвчлан тооцох нь төсвийн төлөвлөлт бодитой, тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлнэ. Энэхүү төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь Засгийн газраас ирүүлсэн төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд санал, дүгнэлт өгөх мэргэшсэн гишүүдээс бүрдэх бөгөөд түүнийг Улсын Их Хурлаас сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилж, чөлөөлөхөөр хуульд тусгасан.

- Төсвийн төлөвлөлтийг бодитой тооцож, үнэн зөв төлөвлөхийг хуульд заасан бөгөөд ийнхүү тооцооллыг буруу тооцоолж, төсвийг баталж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй төлөвлөн зарцуулсан бол уг албан тушаалтанд хариуцлага тооцох нөхцөлийг хуульд тусгасан.

# ДҮГНЭЛТ

- Төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор баталсан нэг чухал өөрчлөлт нь төсвийн тусгай шаардлагыг өөрчлөх, түдгэлзүүлэхтэй холбоотой аливаа шийдвэрийг гаргах бол Улсын Их Хурлын гишүүдийн хувьд өвчтэй, чөлөөтэй, гадаад, дотоод томилолттойгоос бусад тохиолдолд нийт гишүүдийн оролцоотойгоор асуудлыг шийдвэрлэдэг байхаар хуульд тусган баталсан. Ингэснээр төсвийн хариуцлагатай, тогтвортой, төсвийг үр ашигтай төлөвлөдөг байх нөхцөл бүрдэх юм.

- Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, түүний нэмэлт, өөрчлөлтийг баталснаас хойш гурваас доошгүй сарын хугацаанд төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэх, батлахыг хориглох тухай зарчмыг тусган баталсан.

- Хуулийн өөрчлөлтөөр төсвийн цаглаварт өөрчлөлт орсон бөгөөд Засгийн газраас төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө төсвийг олон нийтэд заавал хэлэлцүүлсэн байх, улмаар 9 сарын 1-нд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх асуудлыг тусган баталсан. Улмаар жил бүрийн 9 дүгээр сарын 20-ны өдөр төсвийн тогтортой байдлын зөвлөл, жил бүрийн 9 дүгээр сарын 25-нд төрийн аудитын байгууллага нь төсвийн төсөлд санал, дүгнэлт гаргаж, Улсын Их Хуралд хүргүүлэхээс гадна олон нийтэд нээлттэй мэдээллээ байршуулахаар тусгасан нь Улсын Их Хурлын хяналт шалгалт, хууль батлах, төсвийн төслийг хянахад мэргэжил арга зүй, цаг хугацааны хувьд томоохон дэмжлэг болж байна. /2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхлэнэ/.

# ДҮГНЭЛТ

- Төсвийн тухай хуульд оруулсан бас нэг гол өөрчлөлт нь төсвийн хөрөнгийг захиран зарцуулахад хариуцлагатай байх зарчмыг хэрэгжүүлэхийг тусгасан. Үүнд, төсвийн хөрөнгийг ангилал зөрүүлэн захиран зарцуулсан бол уг төсвийн захирагчийг албан тушаалаас чөлөөлөх нөхцөлийг тусгалаа. /Мөн төсвийн хөрөнгөөр аливаа тэмдэглэлт ой, баяр наадмын арга хэмжээг санхүүжүүлэхгүй байхаар тусгасан/.

- Мөн төсвийн бодлогод томоохон нөлөөлөл үзүүлэх зээл, тусламжийн бодлогын асуудалд мөн өөрчлөлтийг тусгасан. Үүнд төсвийн төлөвлөлтөд шууд нөлөөлдгийн хувьд энэхүү зээлийн хэлэлцээрийг олон нийтэд мэдээлдэг байх, улмаар нийгмийн ач холбогдолтойгоос бусад тохиолдолд эдийн засгийн хувьд бодит үр өгөөж өгөх нөхцөлөөр зээл авах асуудлыг хуульд тусгасан. Зээлийн стратегийг урт хугацаагаар тооцож үр нөлөөг тооцох нь урт хугацааны зээлийн төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцож баталдаг болох нөхцөл бүрдэх юм.

- Мөн шавхагдах баялаг болох эрдэс баялгийн салбарын орлогоос ирээдүй, хойчдоо хувь үлдээх зорилгоор төвлөрүүлдэг ирээдүйн өв сангийн орлогын эх үүсвэрийн найдвартай байдлыг хангах, түүний төлөвлөлт, гүйцэтгэлийн ил тод байдлыг хангах зорилгоор төсвийн төлөвлөлтөд уг сангийн үлдэгдлийн дүнг жил тутам төсвийн хуультай хамт баталдаг байхаар тусгасан. Мөн сангийн хөрөнгийн удирдлагыг Ерөнхий сайд хэрэгжүүлэхээр хуульчлан баталсан.

# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА